

# БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: БНА-2024/191/НА- СТА-ТШЗ**

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Баянхонгор хот

2024 оны 02 дугаар сарын 23-ны өдөр

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын

Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат

Утас: 70442584 Цахим хаяг: [munkhbatb@audit.gov.mn](mailto:munkhbatb@audit.gov.mn)

Аудитын менежер А.Цээням

Утас: 70442424 Цахим хаяг: [tseenyama@audit.gov.mn](mailto:tseenyama@audit.gov.mn)

Ахлах аудитор Б.Должмаа

Утас: 88110538 Цахим хаяг: [doljmaab@audit.gov.mn](mailto:doljmaab@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3 . САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	11
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	15
4.1 Ерөнхий зүйл.....	15
4.2 Материаллаг байдал .....	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	16
4.5.1 Завсрын аудитын талаар .....	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	16
5.1 Албан шаардлага .....	18
5.2 Зөвлөмж.....	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	21

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Орон нутгийн өмчийн газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



БАЯН-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ  
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГА Э.АМГАЛАНБАЯР ТАНАА

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн  
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,  
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101  
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2024.02.25 № 2/21  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

- Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн дүн нь гүйцэтгэлийн үе шатанд тооцсон материаллаг байдлын дүнгээс хэтэрсэн;
- Санхүүгийн тайланд анхан шатны баримтгүй гүйлгээ тусгасан;
- Холбогдох байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлээгүйгээс байгууллагын санхүүгийн тайлангаас биет бус хөрөнгийг хасаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ: төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 13.5 дахь "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", 13.6 дахь "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтууд болон Тохиолдсон байх, Иж бүрэн байх, Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүд, УСНББОУС-31 (Биет бус хөрөнгө)-ийг хангахгүй байна.

5030112

### **Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй, 70106 (Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдах) хөтөлбөрийн арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс баталсан 629,625.9 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн авч, өөрийн орлогоор 1,751.3 мянган төгрөгийг оруулан, гүйцэтгэлээр 573,844.6 мянган төгрөгийг зарцуулж, зардлын хэмнэлтийн 57,532.6 мянган төгрөгийг оны эцэст орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

### **Аудитын гол асуудаг**

Баянхонгор аймгийн ИТХ-ын Хуралдааны 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 13/08 дугаар тогтоолоор тус байгууллагын санхүүгийн тайлан дахь 920,000.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг актлан, аймгийн Орон нутгийн өмчийн газраас өгсөн чиглэлийн дагуу санхүүгийн тайланд акталсан тус хөрөнгөөс зарим хөрөнгийг зах зээлийн ханшаар үнэлэн бүртгэсэн байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын дарга 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг 100 хувиар тайлагнасан байна.

Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй, аудитад ажил гүйлгээг түүврийн аргыг ашиглан гүйцэтгэсэн болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Б.МӨНХБАТ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>145,131,098.00</b>	<b>144,656,903.00</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>103,315,846.00</b>	<b>77,568,211.00</b>
<b>33500</b>	<b>Бусад авлага</b>	<b>103,315,846.00</b>	<b>77,568,211.00</b>
33510	Байгууллагаас авах авлага	103,315,846.00	77,568,211.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>41,815,252.00</b>	<b>67,088,692.00</b>
<b>35100</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>1,581,800.00</b>	<b>1,581,800.00</b>
35110	Тусгай зориулалттай материал	1,581,800.00	1,581,800.00
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>40,233,452.00</b>	<b>56,078,452.00</b>
35410	Бичиг хэргийн материал	1,038,000.00	1,640,000.00
35420	Аж ахуйн материал	273,000.00	6,516,000.00
35470	Бусад хангамжийн материал	38,922,452.00	47,922,452.00
35600	Мал амьтад	0	9,428,440.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,866,630,869.52</b>	<b>2,817,937,231.87</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,866,630,869.52</b>	<b>2,817,937,231.87</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>1,823,643,536.16</b>	<b>2,767,593,631.83</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,961,435,521.29	2,872,267,273.29
39202	Хуримтлагдсан элэгдэл	-1,458,949,010.03	-638,652,003.67
39203	Авто-тээврийн хэрэгсэл	166,604,800.00	305,464,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-102,145,213.39	-112,181,466.72
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	239,133,435.05	303,913,255.05
39206	Хуримтлагдсан элэгдэл	-119,910,501.48	-122,969,984.88
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	72,828,009.00	93,285,359.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-53,863,952.05	-60,893,305.13
39214	Бусад үндсэн хөрөнгө	139,126,487.00	164,126,487.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-44,994,709.23	-61,145,452.11
39217	Ном	24,378,670.00	24,378,670.00
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>42,987,333.36</b>	<b>50,343,600.04</b>
39301	Програм хангамж	975,000.00	975,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-681,666.64	-754,999.96
39303	Бусад биет бус хөрөнгө	42,694,000.00	50,123,600.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>2,011,761,967.52</b>	<b>2,962,594,134.87</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>76,064.12</b>	<b>5,994,000.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>76,064.12</b>	<b>5,994,000.00</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>76,064.12</b>	<b>5,994,000.00</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	76,064.12	0
<b>41360</b>	<b>Бусад өглөг</b>	<b>0</b>	<b>5,994,000.00</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	0	5,994,000.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,011,685,903.40</b>	<b>2,956,600,134.87</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>2,011,685,903.40</b>	<b>2,956,600,134.87</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	693,032,910.00	700,462,510.00
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	693,032,910.00	700,462,510.00
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>1,201,085,482.31</b>	<b>2,151,770,193.78</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	1,026,115,160.60	1,243,985,742.31
51220	Тайлант үеийн үр дүн	174,970,321.71	907,784,451.47
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	117,567,511.09	104,367,431.09
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>2,011,761,967.52</b>	<b>2,962,594,134.87</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>785,178,387.25</b>	<b>1,796,065,253.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>239,949,441.25</b>	<b>1,036,372,542.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>239,949,441.25</b>	<b>1,036,372,542.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>40,658,000.00</b>	<b>1,751,350.00</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,158,000.00	1,751,350.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	37,500,000.00	0
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	199,291,441.25	1,010,321,752.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	0	24,299,440.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>545,228,946.00</b>	<b>759,692,711.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>110,285,646.00</b>	<b>130,066,811.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.00	0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	105,285,646.00	130,066,811.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>434,943,300.00</b>	<b>629,625,900.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	434,943,300.00	629,625,900.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>610,208,065.54</b>	<b>888,280,801.53</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>610,208,065.54</b>	<b>888,280,801.53</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>550,488,134.69</b>	<b>830,348,158.72</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>217,674,132.00</b>	<b>334,677,871.07</b>
210101	Үндсэн цалин	217,674,132.00	270,971,004.66
210102	Нэмэгдэл	0	58,504,016.41
210104	Урамшуулал	0	5,202,850.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>27,744,151.27</b>	<b>42,141,450.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	19,113,813.27	28,716,187.13
210202	Тэтгэмжийн даатгал	2,248,614.00	3,440,278.74
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,765,292.00	3,022,984.34
210204	Ажилгүйдлийн даатгал	417,533.00	632,907.04
210205	Эрүүл мэндийн даатгал	4,198,899.00	6,329,092.75
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>49,638,145.00</b>	<b>58,414,844.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,925,182.00	5,157,813.00
210302	Түлш, халаалт	46,712,963.00	53,257,031.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>85,004,579.00</b>	<b>53,620,564.00</b>
210401	Бичиг хэрэг	4,277,320.00	5,603,030.00
210402	Тээвэр, шатахуун	34,346,360.00	35,406,884.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,925,600.00	3,305,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,344,499.00	7,200,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	511,300.00	2,105,650.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	37,500,000.00	0
210408	Бараа материал акталсны зардал	1,099,500.00	0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>5,801,649.00</b>	<b>29,537,300.00</b>
210604	Урсгал засвар	5,801,649.00	29,537,300.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>5,174,000.00</b>	<b>5,204,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	5,174,000.00	5,204,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>5,247,917.00</b>	<b>112,521,890.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,798,600.00	110,125,850.00
210803	Даатгалын үйлчилгээ	0	64,350.00

210804	Тээврийн хэрэгслийн татвар	701,034.00	599,518.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	0	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,129,000.00	1,445,500.00
210807	Газрын төлбөр	511,283.00	242,672.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	108,000.00	0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>154,203,561.42</b>	<b>194,230,239.65</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,769,260.00	25,157,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	653,600.00	0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	139,780,701.42	169,072,339.65
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>59,719,930.85</b>	<b>57,932,642.81</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>24,530,100.00</b>	<b>400,000.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	19,393,500.00	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,136,600.00	400,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>35,189,830.85</b>	<b>57,532,642.81</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	35,189,830.85	57,532,642.81
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>174,970,321.71</b>	<b>907,784,451.47</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>174,970,321.71</b>	<b>907,784,451.47</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>548,386,946.00</b>	<b>864,759,907.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>3,158,000.00</b>	<b>1,751,350.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>3,158,000.00</b>	<b>1,751,350.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>3,158,000.00</b>	<b>1,751,350.00</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,158,000.00	1,751,350.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>545,228,946.00</b>	<b>863,008,557.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>110,285,646.00</b>	<b>233,382,657.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.00	0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	105,285,646.00	233,382,657.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>434,943,300.00</b>	<b>629,625,900.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	434,943,300.00	629,625,900.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>536,706,946.00</b>	<b>762,132,557.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>536,706,946.00</b>	<b>762,132,557.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>373,671,169.15</b>	<b>656,331,883.19</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>217,598,076.88</b>	<b>332,720,645.32</b>
210101	Үндсэн цалин	184,805,056.65	248,352,400.54
210102	Нэмэгдэл	0	79,165,394.78
210104	Урамшуулал	0	5,202,850.00
210105	Гэрээт ажлын хөлс	32,793,020.23	0
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>27,744,142.27</b>	<b>44,174,739.87</b>
210201	Тэтгэврийн даатгал	19,073,719.27	30,370,574.34
210202	Тэтгэмжийн даатгал	2,262,045.00	3,553,965.96
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,646,858.00	2,824,094.98
210204	Ажилгүйдлийн даатгал	544,885.00	675,279.08

210205	Эрүүл мэндийн даатгал	4,216,635.00	6,750,825.51
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>45,953,825.00</b>	<b>58,117,844.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,875,182.00	4,860,813.00
210302	Түлш, халаалт	43,078,643.00	53,257,031.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>43,653,619.00</b>	<b>46,475,558.00</b>
210401	Бичиг хэрэг	3,936,720.00	2,757,030.00
210402	Тээвэр, шатахуун	29,981,100.00	31,931,128.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,017,600.00	3,602,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,147,999.00	7,593,750.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	570,200.00	591,650.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4,500,000.00</b>	<b>32,419,300.00</b>
210604	Урсгал засвар	4,500,000.00	32,419,300.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>5,174,000.00</b>	<b>5,204,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	5,174,000.00	5,204,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>4,359,117.00</b>	<b>117,703,316.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,969,800.00	114,487,276.00
210803	Даатгалын үйлчилгээ	0	64,350.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	701,034.00	599,518.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	0	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,069,000.00	2,265,500.00
210807	Газрын төлбөр	511,283.00	242,672.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	108,000.00	0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>24,688,389.00</b>	<b>19,516,480.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	24,034,789.00	19,516,480.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	653,600.00	0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>163,035,776.85</b>	<b>105,800,673.81</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>24,530,100.00</b>	<b>400,000.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	19,393,500.00	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,136,600.00	400,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>138,505,676.85</b>	<b>105,400,673.81</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	35,189,830.85	57,532,642.81
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	103,315,846.00	47,868,031.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>11,680,000.00</b>	<b>102,627,350.00</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>11,680,000.00</b>	<b>102,627,350.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>11,680,000.00</b>	<b>102,627,350.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>11,680,000.00</b>	<b>102,627,350.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	11,680,000.00	102,627,350.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-11,680,000.00</b>	<b>-102,627,350.00</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	693,032,910.00	117,873,841.09	1,025,808,830.60	1,836,715,581.69
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	306,330.00	306,330.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	693,032,910.00	117,873,841.09	1,026,115,160.60	1,837,021,911.69
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	-306,330.00	0	-306,330.00
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
7	Өмчид гарсан өөрчилтөл	0	0	0	0
8	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
9	Тайлант үеийн үр дүн	0	0	174,970,321.71	174,970,321.71
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	693,032,910.00	117,567,511.09	1,201,085,482.31	2,011,685,903.40
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	693,032,910.00	117,567,511.09	1,201,085,482.31	2,011,685,903.40
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	42,900,260.00	42,900,260.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	693,032,910.00	117,567,511.09	1,243,985,742.31	2,054,586,163.40
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	-13,200,080.00	0	-13,200,080.00
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	7,429,600.00	0	0	7,429,600.00
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
17	Өмчид гарсан өөрчлөлт	0	0	0	0
18	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
19	Тайлант үеийн үр дүн	0	0	907,784,451.47	907,784,451.47
20	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	700,462,510.00	104,367,431.09	2,151,770,193.78	2,956,600,134.87

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	630,625,900.00	573,844,607.19	56,781,292.81	91.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	630,625,900.00	573,844,607.19	56,781,292.81	91.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	628,225,900.00	573,444,607.19	54,781,292.81	91.28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	349,074,500.00	332,720,645.32	16,353,854.68	95.32
210101	Үндсэн цалин	255,668,500.00	248,352,400.54	7,316,099.46	97.14
210102	Нэмэгдэл	93,406,000.00	79,165,394.78	14,240,605.22	84.75
210104	Урамшуулал	0	5,202,850.00	-5,202,850.00	#DIV/0!
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,759,600.00	44,174,739.87	584,860.13	98.69
210201	Тэтгэврийн даатгал	30,436,500.00	30,370,574.34	65,925.66	99.78
210202	Тэтгэмжийн даатгал	3,580,800.00	3,553,965.96	26,834.04	99.25
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,864,600.00	2,824,094.98	40,505.02	98.59
210204	Ажилгүйдлийн даатгал	716,100.00	675,279.08	40,820.92	94.30
210205	Эрүүл мэндийн даатгал	7,161,600.00	6,750,825.51	410,774.49	94.26
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	64,278,800.00	58,117,844.00	6,160,956.00	90.42

210301	Гэрэл, цахилгаан	6,100,000.00	4,860,813.00	1,239,187.00	79.69
210302	Түлш, халаалт	57,178,800.00	53,257,031.00	3,921,769.00	93.14
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	0	1,000,000.00	0.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>50,319,300.00</b>	<b>46,475,558.00</b>	<b>3,843,742.00</b>	<b>92.36</b>
210401	Бичиг хэрэг	4,159,100.00	2,757,030.00	1,402,070.00	66.29
210402	Тээвэр, шатахуун	32,400,000.00	31,931,128.00	468,872.00	98.55
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,800,200.00	3,602,000.00	1,198,200.00	75.04
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	8,360,000.00	7,593,750.00	766,250.00	90.83
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	600,000.00	591,650.00	8,350.00	98.61
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>39,900,000.00</b>	<b>32,419,300.00</b>	<b>7,480,700.00</b>	<b>81.25</b>
210604	Урсгал засвар	39,900,000.00	32,419,300.00	7,480,700.00	81.25
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>6,695,700.00</b>	<b>5,204,000.00</b>	<b>1,491,700.00</b>	<b>77.72</b>
210702	Дотоод албан томилолт	6,695,700.00	5,204,000.00	1,491,700.00	77.72
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>39,648,000.00</b>	<b>34,574,040.00</b>	<b>5,073,960.00</b>	<b>87.20</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	34,186,000.00	31,358,000.00	2,828,000.00	91.73
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	0	500,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	100,000.00	64,350.00	35,650.00	64.35
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,018,000.00	599,518.00	418,482.00	58.89
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	140,000.00	44,000.00	96,000.00	31.43
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,604,000.00	2,265,500.00	338,500.00	87.00
210807	Газрын төлбөр	800,000.00	242,672.00	557,328.00	30.33
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	300,000.00	0	300,000.00	0.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>33,550,000.00</b>	<b>19,758,480.00</b>	<b>13,791,520.00</b>	<b>58.89</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	33,550,000.00	19,758,480.00	13,791,520.00	58.89
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,400,000.00</b>	<b>400,000.00</b>	<b>2,000,000.00</b>	<b>16.67</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>2,400,000.00</b>	<b>400,000.00</b>	<b>2,000,000.00</b>	<b>16.67</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	400,000.00	0	400,000.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	400,000.00	1,600,000.00	20.00
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>630,625,900.00</b>	<b>573,844,607.19</b>	<b>56,781,292.81</b>	<b>91.00</b>
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>629,625,900.00</b>	<b>572,093,257.19</b>	<b>57,532,642.81</b>	<b>90.86</b>
320001	Орон нутгийн төсвөөс	629,625,900.00	572,093,257.19	57,532,642.81	90.86
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>1,000,000.00</b>	<b>1,751,350.00</b>	<b>-751,350.00</b>	<b>175.14</b>
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	1,751,350.00	-751,350.00	175.14
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>43</b>	<b>43</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
610001	Төсвийн байгууллага	1	1	0.00	100.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>24</b>	<b>24</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
620001	Удирдах ажилтан	7	7	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	11	11	0.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	3	3	0.00	100.00
620004	Гэрээт ажилтан	3	3	0.00	100.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>24</b>	<b>24</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	8	8	0.00	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	7	7	0.00	100.00
650010	Гэрээт ажилтан	3	3	0.00	100.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	6	6	0.00	100.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>233,382,657.00</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	233,382,657.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	185,514,626.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	185,514,626.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	185,514,626.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	47,868,031.00
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	47,868,031.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>233,382,657.00</b>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	233,382,657.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	233,382,657.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	<b>0.00</b>
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00

## 3 . САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын ЗДТГ "Орчин үеийн техник технологийг нэвтрүүлж, мэргэжил, боловсрол, дадлага туршлагатай мэргэшсэн хүний нөөцийг тушиглэн төрийн ажил үйлчилгээг байгууллага, иргэдэд чадварлаг бүтцээр хөнгөн шуурхай хүртээмжтэй хүргэх" эрхэм зорилготой тус байгууллага нь үндсэн 21, гэрээт ажилтан 2, нийт 24 орон тоотой үйл ажиллагаа явуулсан байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг дарга Э.Амгаланбаяр, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Х.Уранчимэг нар зурж, нярваар Г.Наранцэцэг 2023 оны 1-6 сар хүртэл, А.Энхбаяр 7-12 сар хүртэл ажиллажээ.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Мэдээллийн ил тод байдлын тухай, Шилэн дансны тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Байгууллагын нууцын тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Нийгмийн даатгалын тухай, Архивын тухай болон Татварын багц хуулиудыг мөрдөж үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Тайлант онд шинээр Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдсөн;
- Хөдөлмөрийн тухай хуулийг шинэчилснийг мөрдсөн;

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авсан ба дотоод аудит гүйцэтгээгүй тул аудитад ашиглах баримт материал байхгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж буй Баянхонгор аймгийн СТСХ-ээс бэлтгэж гаргасан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 950,908.2 мянган төгрөгөөр буюу 47 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	103,315.8	77,568.2	(25,747.6)
Бараа материал	41,815.2	67,088.6	25,273.4
Үндсэн хөрөнгө	3,647,175.9	4,734,534.4	1,087,358.5
Хуримтлагдсан элэгдэл	(1,780,545.1)	(1,916,597.2)	(136,052.2)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>2,011,762.0</b>	<b>2,962,594.1</b>	<b>950,832.2</b>
Өр төлбөр	76.1	5,994.0	5,917.9
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,011,685.9	2,956,600.1	944,914.2
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>2,011,762.0</b>	<b>2,962,594.1</b>	<b>950,908.2</b>

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын ЗДТГ-ын санхүүгийн тайлан

Дээрх хүснэгтээс харахад Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын ЗДТГ-ын 2022 оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан дансанд нь авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данс байна.

Тайланд онд авлага өмнөх оноос 25,747.6 мянган төгрөгөөр буурч, 77,568.2 мянган төгрөг болсон, оны эхний нэмэлт санхүүжилтийн авлагын 103,315.8 мянган төгрөг барагдсан бөгөөд оны эцэст нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдлийг төсөвт төвлөрүүлснээр 47,868.0 мянган төгрөгийн авлага үүссэн, аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн А/379 дүгээр албан бичгээр 2016 онд “Шижир аранжин” ХХК-д мотор түрээслүүлсний орлогын 29,700.2 мянган төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд нэмэх шийдвэрийг өгснөөр авлагын үлдэгдэлтэй гарчээ.

Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 25,273.4 мянган төгрөгөөр нэмэгдэж, 67,088.6 мянган төгрөг болсон нь Баянхонгор аймгийн ИТХ-ын даргын 2023 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 107 дугаар захирамжаар 9,428.4 мянган төгрөгийн Баянбулаг омгийн хурган хуц, Сэлэнгэ үүлдрийн бухан бяруу олгосон, аймгийн ЗДТГ-аас өгсөн 9,996.0 мянган төгрөгийн өвс олгосон, “Green Pontam” ХХК-аас 4,875.0 мянган төгрөгийн мод, үр, суулгацыг хандиваар өгсөнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө өмнөх оноос 1,087,358.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь 7,429.6 мянган төгрөгийн газрыг бүртгэсэн, “Green Pontam” ХХК-аас 12,450.0 мянган төгрөгийн хүлэмж, тоног төхөөрөмж, аймгийн Байгаль, орчин аялал жуулчлалын газраас 13,460.0 мянган төгрөгийн 3 тоног төхөөрөмж, сумын ОНХС-ийн санхүүжилтээр 454,455.3 мянга, аймгийн ОНХС-ийн санхүүжилтээр 37,064.0 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, Онцгой байдлын Ерөнхий газраас 78,000.0 мянган төгрөгийн УАЗ 469 автомашин үнэ төлбөргүй ирсэнтэй холбоотой байна. Тайланд онд 102,627.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр худалдан авч, бүртгэлд бүрэн тусгажээ.

Өмнөх онд өглөггүй ажилласан ба 2023 оны жилийн эцэст гүйлгээ батлагдаагүйгээс “НИК” ХХК-д өвс тэжээл татаж авсан шатахууны зардлын 5,994.0 мянган төгрөгийн өглөгтэй гарчээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайланд үеийн үр дүнгийн 907,784.4 мянган төгрөгөөр нэмэгдэж, 2,956,600.1 мянган төгрөг болсон байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2023 оны төсвийн төслийг 490,321.2 мянган төгрөгөөр баталж, аймгийн СТСХ-т хүргүүлсэн байна.

Баян-Өндөр сумын ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 13/69 дүгээр тогтоолоор сумын ЗДТГ-ын төсвийг хүргүүлсэн төсвийн төслөөс 19,405.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 198,502.9 мянган төгрөгөөр баталсан нь тогтмол зардал, урсгал засварын зардлыг нэмж баталсантай холбоотой байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Оны эхэнд баталсан төсвийг 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 17/86 дугаар тогтоолоор 120,899.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 630,625.9 мянган төгрөгөөр баталж, 629,625.9 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс олгож, 1,000.0 мянган төгрөгийг өөрийн орлогоор оруулахаар төлөвлөжээ.

Тайлант онд тус байгууллага төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 70106 (Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдах) хөтөлбөрийн арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс баталсан 629,625.9 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн авч, өөрийн орлогоор 1,751.3 мянган төгрөгийг оруулан, гүйцэтгэлээр 573,844.6 мянган төгрөгийг зарцуулж, зардлын хэмнэлтийн 57,532.6 мянган төгрөгийг оны эцэст орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Байгууллага өөрийн орлогоор 1,000.0 мянган төгрөгийг оруулахаар төлөвлөснөөс заалны түрээсийн орлогоор 1,751.3 мянган төгрөгийг оруулж, төлөвлөгөө биелүүлж ажиллажээ.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөгөөр/*

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
21	УРСГАЛ ЗАРДАЛ	630,625.90	573,844.61	56,781.29	91.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	349,074.50	332,720.65	16,353.85	95.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,759.60	44,174.74	584.86	98.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	64,278.80	58,117.84	6,160.96	90.4
2104	Хангамж, бараа материалын зардал	50,319.30	46,475.56	3,843.74	92.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	39,900.00	32,419.30	7,480.70	81.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	39,648.00	34,574.04	5,073.96	87.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33,550.00	19,758.48	13,791.52	58.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,400.00	400.00	2,000.00	16.7

*Эх сурвалж: Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын ЗДТГ-ын төсвийн хэлбэлзэл*

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар 233,382.6 мянган төгрөгийн орлого орсныг зориулалтын дагуу зарцуулж, хэмнэгдсэн зардлыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэн авлагаар бүртгэсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын ЗДТГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн шийдвэрийг үндэслэн гаргасан холбогдох шийдвэрийн дагуу сэлбэг хэрэгслийг худалдан авч, суудлын автомашины хувийн хэргийн хөтлөлтийг сайжруулах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын ахлах аудитор Б.Должмаа гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх тухай албан бичгийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023.11.23-ны өдрийн 3/73 дүгээр албан бичгээр ирүүлж, санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг 2024.01.25-ны өдөр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант жилийн батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны батлагдсан төсвийн 630,625.9 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 6,306.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 4,414.4 мянган төгрөгөөр тогтоосон.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын ЗДТГ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллагад 2023 оны 12 дугаар сард гүйцэтгэсэн завсрын аудитаар байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 10,000.0 мянган төгрөгийн 2 орлогын гүйлгээ, 5,000.0 мянган төгрөгийн 1 зарлагын гүйлгээ болон 32,897.2 мянган төгрөгийн 10 шийдвэр, тайланд онд байгуулсан 4 гэрээг байршуулаагүй орхигдуулсан зөрчил илэрсэнд зөрчлийг арилгах чиглэл өгч, мэдээллүүдийг нөхөн байршуулсан байгаа тул санхүүгийн тайланд залруулснаар тайлагнав.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Тус байгууллагад завсрын аудитыг 2023 оны 12 дугаар сард гүйцэтгэж, аудитаар нийт 317,683.7 мянган төгрөгийн 12 зөрчил илэрч, зөрчлийг арилгах зөвлөмж өгсөн бөгөөд оны эцсийн санхүүгийн тайланд аудит хийхэд завсрын аудитаар өгсөн зарим зөвлөмжийг бүрэн биелүүлсэн, холбогдох арга хэмжээг авсан байгаа тул хэрэгжилтийг тооцож, асуудлын бүртгэлээс хассан болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Амаржаргал гүйцэтгэж, 29,700.2 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	29,700.2	1	29,700.2	100
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>29,700.2</b>	<b>1</b>	<b>29,700.2</b>	<b>100</b>

Эх сурвалж: Баян-Өндөр сумын ЗДТГ-ын 2023.05.25-ны өдрийн 1/77 дугаар албан бичиг

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Баян-Өндөр сумын ЗДТГ-ын даргын гарын үсгийн дардас ашиглан байгууллагын нярав даргыг эзгүй байх хугацаанд 4,359.7 мянган төгрөгийн шаардах хуудаст дарж, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг зөрчсөн байгаа асуудлыг таслан зогсоож цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх нь зүйтэй байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Санхүүгийн тайлангийн завсрын болон жилийн эцсийн аудитаар нийт 1,188,668.2 мянган төгрөгийн дараах 7 алдаа илэрч, аудитын явцад санхүүгийн тайланд залруулсан. Үүнд:

1. Баянхонгор аймгийн ИТХ-ын 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 13/08 дугаар захирамжаар тус байгууллагын барилга байгууламжид бүртгэлтэй 920,000.0 мянган төгрөгийн өртөг бүхий сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмжийг акталсан байхад нягтлан бодох бүртгэлээс хасаагүй байгаа нь Үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй;
2. Байгууллагын нягтлан бодогч 2023 оны 9 дүгээр сарын шуудан холбооны зардлын 297.0 мянган төгрөгийг гэрэл цахилгааны зардлаар тайлагнасан нь Ангилал батламж мэдэгдлийг хангаагүй;
3. Байгууллагын нягтлан бодогч 2021 онд бүртгэсэн 1,669.9 мянга, 2022 онд бүртгэсэн 159,255.7 мянга, 2023 онд бүртгэсэн 6,450.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн ашиглах жилийг 0 болон -1 жилээр бүртгэснээс шалтгаалан тус үндсэн хөрөнгүүдэд элэгдэл бодогдоогүй байгаа нь Иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаагүй;
4. Бараа материалын оны эхний үлдэгдлийн 336.0 мянган төгрөгийн өвс, 3,045.0 мянган төгрөгийн үрийн будаа, 9,112.5 мянган төгрөгийн хивэг зэрэг бараа материалыг оны туршид зарлагадаагүй, завсрын аудитаар тулгах горим сорилыг хэрэгжүүлэх байсан ч агуулахад эмх замбараагүй, тоолох боломжгүй, нярав солигдсон байхад бараа материалыг тоолж хүлээлцээгүй байгаа нь Үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй;
5. Санхүүгийн тайлангийн завсрын аудитаар байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд өмнөх оны санхүүжилтийн авлагаас 2023.10.13-ны өдөр 29,669.7 мянга, 2023.10.27-ны өдөр Сангийн сайдын 149 дүгээр тушаалаар 100,000.0 мянган төгрөгийн орлого орсон байхад нягтлан бодогч санхүүгийн тайланд бүртгээгүй нь Тасалбар болголт батламж мэдэгдлийг хангаагүй;
6. Санхүүгийн тайлангийн завсрын аудитаар Баянхонгор аймгийн ИТХ-ын даргын 2023.11.13-ны өдрийн 107 дугаар захирамжаар олгосон 52,072.4 мянган төгрөгийн 4 нэр төрлийн үндсэн хөрөнгө, мал амьтад, хандиваар ирсэн 55,000.0 мянган төгрөгийн автомашиныг бүртгэлд тусгаагүй нь Ангилал батламж мэдэгдлийг хангаагүй;
7. Тайлант онд үнэ төлбөргүй ирсэн 1,400.0 мянган төгрөгийн 2 үндсэн хөрөнгийг буруу дансанд бүртгэсэн нь Ангилал батламж мэдэгдлийг хангаагүй тул санхүүгийн тайланд залруулга хийсэн.

Аудитаар нийт 17,438.1 мянган төгрөгийн 6 зөрчил<sup>1</sup> илэрснээс 1,264.5 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, 9,586.1 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлага өгч, 6,587.5 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмжийг менежментийн захидлаар өглөө.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 5.1. Төлбөрийн акт

1. Байгууллагын төсвөөс 5,000.0 мянган төгрөгийн хорголжин тэжээлийг малчдад тараасан анхан шатны баримтад 79 малчдад тараасан байхад 100 малчин өрхөд олгосноор зарлагадсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 13.5 дахь “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна”, 13.6 дахь “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын төсвийн захирагч, нягтлан бодогч нараар төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

2. Малчид, төлчдийн зөвлөгөөнд олгосон 1,195.0 мянган төгрөгийн шагнал, мал тооллогын урамшуулалд олгосон 450.0 мянган төгрөгөөс хувь хүний орлогын албан татварыг суутган тооцоогүй байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.6 дахь “Албан татвар төлөгчийн дараах орлогод албан татвар ногдоно: 6.3.6.бусад орлого”, 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх “12.1.Энэ хуулийн 6.3.6-д заасан орлогод дараах орлогыг хамруулна: 12.1.1.урлаг, спортын тэмцээний шагнал, наадмын бай шагнал, тэдгээртэй адилтгах бусад орлого” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын төсвийн захирагч, нягтлан бодогч нараар төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

3. Санхүүгийн тайлангийн завсрын аудитаар бараа материалыг түүвэрлэн биет тооллого хийхэд 45.0 мянган төгрөгийн бал, 5.0 мянган төгрөгийн дэвтэр дутагдсан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын төсвийн захирагч, нягтлан бодогч нараар төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

## 5.2. Албан шаардлага

1. Баян-Өндөр сумын 100 жилийн ойг 2023 оны 07 дугаар сарын 19-21-ний өдрүүдэд тэмдэглэж, "Бай баян өндөр" хоршоонд 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдөр тус ойн арга хэмжээний зардалд 5,000.0 мянган төгрөгийг олгосон байхад санхүүгийн баримтад анхан шатны баримтыг хавсаргаагүй, байгууллагын үндсэн төсвөөс ойн арга хэмжээний зардалд 3,012.2 мянган төгрөгийн зардлыг олгохдоо холбогдох шийдвэрийг гаргаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 13.5 дахь "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Засгийн Газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор баталсан "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам"-ын 3.2.1.1-т "Байгууллага нь үндсэн үйл ажиллагааны болон хүний нөөцийн чиглэлээр тус тусад нь тушаал, захирамж гаргана: байгууллагын үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой төсөв, зардал батлах, хөрөнгө зарцуулах зэрэг асуудалд холбогдох тушаал, захирамж хамаарна" гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Сумын ойг тэмдэглэхэд олгосон зардлын анхан шатны баримтыг санхүүгийн баримтад хавсаргах, төсвийн хөрөнгийг холбогдох шийдвэрээр зарцуулж байх албан шаардлагыг хүргүүлэв.

2. Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас ирүүлсэн судалгааг тус байгууллагын нягтлан бодох бүртгэлд тусгасан газартай тулган шалгахад Баян-Өндөр сумын ЗДТГ-т эрх бүхий байгууллагын шийдвэрээр олгосон ус түгээх газрыг санхүүгийн тайланд тусгаагүй, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны 72 дугаар тогтоолоор хуучин ЗДТГ-ын барилгыг газрын хамт дуудлага худалдаагаар худалдсан байхад 1,574.0 мянган төгрөгийн өртөг бүхий тус газрыг бүртгэлээс хасаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна" гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Ус түгээх газрыг санхүүгийн тайланд тусгах, дуудлага худалдаагаар худалдсан газрыг бүртгэлээс хасах албан шаардлагыг хүргүүлэв.

## 5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### 1. Хариуцлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын төсвийн захирагч урсгал засварын зардал, сэлбэг хэрэгсэл худалдан авах шийдвэрийг гаргаагүй, автомашинд олгож байгаа сэлбэг хэрэгслийг автомашины хувийн хэрэгт бүртгээгүй байна.

Энэ нь Засгийн Газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор баталсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ын 3.2.1.1-т “Байгууллага нь үндсэн үйл ажиллагааны болон хүний нөөцийн чиглэлээр тус тусад нь тушаал, захирамж гаргана: байгууллагын үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой төсөв, зардал батлах, хөрөнгө зарцуулах зэрэг асуудалд холбогдох тушаал, захирамж хамаарна”, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 04 сарын 03-ны өдрийн 86 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журам”-ын 3.13-т “Өмч хамгаалах зөвлөл нь хуулийн этгээдийн тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн ашиглалт, сэлбэг эд ангийг солих, барилга байгууламжийн их засвар хийх тохиолдолд батлагдсан норм стандартыг мөрдүүлэх, барилгын болон техникийн хувийн хэрэгт нь баяжилт хийлгэх зэргээр хяналт тавьж ажиллана” гэснийг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Өмч хамгаалах зөвлөл, байгууллагын даргын шийдвэрийг үндэслэн төсвийн хөрөнгийг зарцуулж, автомашины хувийн хэргийг тухай бүрд хөтөлж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох албан хаагчдад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл (мянган төгрөгөөр)

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Баянхонгор аймгийн ИТХ-ын 2023 оны 13/08 дугаар захирамжаар тус байгууллагын барилга байгууламжид бүртгэлтэй 920,000.0 мянган төгрөгийн өртөг бүхий сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмжийг акталсан байхад нягтлан бодох бүртгэлээс хасаагүй байна.	1	920,000.0	1	920,000.0			1	920,000.0		
Байгууллагын нягтлан бодогч 2023 оны 9 дүгээр сарын шуудан холбооны зардлын 297.0 мянган төгрөгийг гэрэл цахилгааны зардлаар тайлагнасан байна.	1	297.0			1	297.0	1	297.0		
Байгууллагын нягтлан бодогч 2021 онд бүртгэсэн 1,669.9 мянга, 2022 онд бүртгэсэн 159,255.7 мянга, 2023 онд бүртгэсэн 6,450.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн ашиглах жилийг 0 болон -1 жилээр бүртгэснээс шалтгаалан тус үндсэн хөрөнгүүдэд элэгдэл бодогдоогүй байна.	1	17,705.6	1	17,705.6			1	17,705.6		

<p>Бараа материалын оны эхний үлдэгдлийн 336.0 мянган төгрөгийн өвс, 3,045.0 мянган төгрөгийн үрийн будаа, 9,112.5 мянган төгрөгийн хивэг зэрэг бараа материалыг оны туршид зарлагдаагүй, завсрын аудитаар тулгах горим сорилыг хэрэгжүүлэх байсан ч агуулахад эмх замбараагүй, тоолох боломжгүй, нярав солигдсон байхад бараа материалыг тоолж хүлээлцээгүй байна.</p>	1	12,493.5	1	12,493.5			1	12,493.5		
<p>Санхүүгийн тайлангийн завсрын аудитаар байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд өмнөх оны санхүүжилтийн авлагаас 2023.10.13-ны өдөр 29,669.7 мянга, 2023.10.27-ны өдөр Сангийн сайдын 149 дүгээр тушаалаар 100,000.0 мянган төгрөгийн орлого орсон байхад нягтлан бодогч санхүүгийн тайланд бүртгээгүй байна.</p>	1	129,699.7	1	129,699.7			1	129,699.7		
<p>Баянхонгор аймгийн ИТХ-ын даргын 2023.11.13-ны өдрийн 107 дугаар захирамжаар олгосон 52,072.4 мянган төгрөгийн 4 нэр төрлийн</p>	1	107,072.4	1	107,072.4			1	107,072.4		

үндсэн хөрөнгө, мал амьтад, хандиваар ирсэн 55,000.0 мянган төгрөгийн автомашиныг бүртгэлд тусгаагүй байна.										
Тайлант онд үнэ төлбөргүй ирсэн 1,400.0 мянган төгрөгийн 2 үндсэн хөрөнгийг буруу дансанд бүртгэсэн байна.	1	1,400.0			1	1,400.0	1	1,400.0		
<b>ДҮН</b>	<b>7</b>	<b>1,188,668.2</b>	<b>5</b>	<b>1,186,971.2</b>	<b>2</b>	<b>1,697.0</b>	<b>7</b>	<b>1,188,668.2</b>	<b>0</b>	<b>0</b>

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл (мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Байгууллагын төсвөөс 5,000.0 мянган төгрөгийн хорголжин тэжээлийг 79 малчдад тараасан байхад 100 малчин өрхөд олгосноор зарлагадсан байна.	1	1,050.0	1	1,050.0								
Малчид, төлчдийн зөвлөгөөнд олгосон 1,195.0 мянган төгрөгийн шагнал, мал тооллогын урамшуулалд олгосон 450.0 мянган төгрөгөөс хувь хүний орлогын албан татварыг суутган тооцоогүй байна.	1	164.5	1	164.5								
Санхүүгийн тайлангийн завсрын аудитаар бараа материалыг түүвэрлэн биет тооллого хийхэд 50.0 мянган төгрөгийн бараа	1	50.0	1	50.0								

материал дутагдсан.													
Баян-Өндөр сумын 100 жилийн ойг тэмдэглэхэд олгосон 5,000.0 мянган төгрөгийн зардлын анхан шатны баримтыг санхүүгийн баримтад хавсаргаагүй 3,012.2 мянган төгрөгийн зардлыг олгохдоо холбогдох шийдвэрийг гаргаагүй байна.	1	8,012.1			1	8,012.1							
Баян-Өндөр сумын ЗДТГ-т эрх бүхий байгууллагын шийдвэрээр олгосон ус түгээх цэгийн газрыг санхүүгийн тайланд тусгаагүй, хуучин ЗДТГ-ын барилгыг газрын хамт дуудлага худалдаагаар худалдсан байхад 1,574.0 мянган төгрөгийн өртөг бүхий тус газрыг бүртгэлээс хасаагүй байна.	1	1,574.0			1	1,574.0							
Байгууллагын төсвийн захирагч урсгал засварын зардал, сэлбэг хэрэгсэл худалдан авах шийдвэрийг гаргаагүй, автомашинд олгож байгаа сэлбэг хэрэгслийг автомашины хувийн хэрэгт бүртгээгүй байна.	1	6,587.5					1	6,587.5					
Дүн	6	17,438.10	3	1,264.5	2	9,586.10	1	6,587.50	0	0	0	0	0

---oOo---



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 190/1/А0560232/БНА  
2024/191/НА -СТА -ТШЗ

Номгон

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Баян-Өндөр сумын 100 жилийн ойг 2023 оны 07 дугаар сарын 19-21-ний өдрүүдэд тэмдэглэж, "Бай баян өндөр" хоршоонд 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдөр тус ойн арга хэмжээний зардалд 5,000,000 (Таван сая) төгрөгийг олгосон байхад санхүүгийн баримтад анхан шатны баримтыг хавсаргаагүй, байгууллагын үндсэн төсвөөс ойн арга хэмжээний зардалд 3,012,100 (Гурван сая арван хоёр мянга нэг зуун) төгрөгийн зардлыг олгохдоо холбогдох шийдвэрийг гаргаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 13.5 дахь "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Засгийн Газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор баталсан "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам"-ын 3.2.1.1-т "Байгууллага нь үндсэн үйл ажиллагааны болон хүний нөөцийн чиглэлээр тус тусад нь тушаал, захирамж гаргана: байгууллагын үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой төсөв, зардал батлах, хөрөнгө зарцуулах зэрэг асуудалд холбогдох тушаал, захирамж хамаарна" гэснийг зөрчсөн байна.

5040574

D/2024-ASH

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт өөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8 дахь "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 2.1.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Сумын ойг тэмдэглэхэд олгосон зардлын анхан шатны баримтыг санхүүгийн баримтад хавсаргах, төсвийн хөрөнгийг холбогдох шийдвэрээр зарцуулж, байх, албан шаардлагыг хэрэгжүүлэн ажилласан тухай нотлох баримтыг 2024 оны 04 дүгээр сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх<sup>1</sup>

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын дарга Н.Амгаланбаяр, нягтлан бодогч Б.Уранчимэг нарт даалгав<sup>2,3</sup>.

#### АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН<sup>4</sup>:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Б.МӨНХБАТ

АХЛАХ АУДИТОР:

Б.ДОЛЖМАА

<sup>1</sup> Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

<sup>2</sup> Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

<sup>3</sup> Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

<sup>4</sup> Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 191/2/АОСГ/0238/НАА

Номгон

2024/191/НА - СТА - ТМБ

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас ирүүлсэн судалгааг тус байгууллагын нягтлан бодох бүртгэлд тусгасан газартай тулган шалгахад Баян-Өндөр сумын ЗДТГ-т эрх бүхий байгууллагын шийдвэрээр олгосон ус түгээх цэгийн газрыг санхүүгийн тайланд тусгаагүй, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны 72 дугаар тогтоолоор хуучин ЗДТГ-ын барилгыг газрын хамт дуудлага худалдаагаар худалдсан байхад 1,574,000 (Нэг сая таван зуун далан дөрвөн мянган) төгрөгийн өртөг бүхий тус газрыг бүртгэлээс хасаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэснийг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх “хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа,

5040579

D/2024-ASH

зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Байгууллагын санхүүгийн тайланд газрыг бүртгэн зөрчлийг арилган, нотлох баримтыг FAS системд оруулж, нотлох баримтыг 2024 оны 04 дүгээр сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх<sup>1</sup>

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэн, нягтлан бодох бүртгэлд тавих хяналтыг сайжруулж ажиллахыг Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын дарга Э.Амгаланбаяр, нягтлан бодогч Б.Уранчимэг нарт даалгав<sup>2,3</sup>.

#### АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Б.МӨНХБАТ

АХЛАХ АУДИТОР:

Б.ДОЛЖМАА

<sup>1</sup> Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

<sup>2</sup> Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

<sup>3</sup> Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

<sup>4</sup> Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2024 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 102/1/АОСБ0238/ВНА  
2024/191/НА-СТА-ТМБ

Номгон

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын 2023 оны төсвөөс 5,000,000 (Таван сая) төгрөгийн хорголжин тэжээлийг малчдад тараасан анхан шатны баримтад 79 малчдад тараасан байхад 100 малчин өрхөд олгосноор зарлагадсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 13.5 дахь "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", 13.6 дахь "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэснийг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8 дахь "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 2.1.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Анхан шатны баримтгүй олгосон 1,050,000 (Нэг сая тавин мянган) төгрөгийг Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын дарга Н.Амгаланбаяр, нягтлан бодогч Б.Уранчимэг нараар төлүүлж, Төрийн сан дахь 100030000947 тоот төгрөгийн дансанд төлбөрийг төвлөрүүлэх.

5050344

2. Аудитаар тогтоосон 1,050,000 (Нэг сая тавин мянган) төгрөгийн төлбөрийн актыг бүрэн барагдуулж, нотлох баримтыг 2024 оны 05 дугаар сарын 10-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт<sup>1</sup> ирүүлэхийг Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын дарга Э.Амгаланбаяр, нягтлан бодогч Б.Уранчимэг нарт даалгав<sup>2,3</sup>.

**ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН<sup>4</sup>:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

Б.МӨНХБАТ

Б.ДОЛЖМАА

<sup>1</sup> Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

<sup>2</sup> Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана"

<sup>3</sup> Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

<sup>4</sup> Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2024 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 103/2/АОСБСЗСЗ/БНА  
2024/191/НА -ОТА -ТМЗ

Номгон

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Малчид, төлчдийн зөвлөгөөний шагналд олгосон 1,195,000 (Нэг сая нэг зуун ерэн таван мянган) төгрөг, мал тооллогын урамшуулалд олгосон 450,000 (Дөрвөн зуун тавин мянган) төгрөгөөс хувь хүний орлогын албан татварт 164,500 (Нэг зуун жаран дөрвөн мянга таван зуун) төгрөгийг суутган тооцоогүй байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.6 дахь "Албан татвар төлөгчийн дараах орлогод албан татвар ногдоно: 6.3.6.бусад орлого", 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх "12.1.Энэ хуулийн 6.3.6-д заасан орлогод дараах орлогыг хамруулна: 12.1.1.урлаг, спортын тэмцээний шагнал, наадмын бай шагнал, тэдгээртэй адилтгах бусад орлого" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8 дахь "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 2.1.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Шагнал, урамшууллаас суутган тооцоогүй хувь хүний орлогын албан татварын

5050349

D/2024-Akt

164,500 (Нэг зуун жаран таван мянга таван зуун) төгрөгийг байгууллагын дарга, нягтлан бодогч нараар төлүүлэн, Төрийн сан дахь 100030000947 тоот төгрөгийн дансанд төлбөрийг төвлөрүүлэх.

2. Аудитаар тогтоосон 164,500 (Нэг зуун жаран таван мянга таван зуун) төгрөгийн төлбөрийн актыг бүрэн барагдуулж, нотлох баримтыг 2024 оны 05 дугаар сарын 10-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт<sup>1</sup> ирүүлэхийг Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын дарга Э.Амгаланбаяр, нягтлан бодогч Б.Уранчимэг нарт даалгав<sup>2, 3</sup>.

#### ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН<sup>4</sup>:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АХЛАХ АУДИТОР

Б.МӨНХБАТ  
Б.ДОЛЖМАА

<sup>1</sup> Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

<sup>2</sup> Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана"

<sup>3</sup> Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

<sup>4</sup> Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2024 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 104/Б/АОСБ0223/БАА  
2024/191/НА - СТА - ТМБ

Номгон

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Санхүүгийн тайлангийн завсрын аудитаар бараа материалыг түүвэрлэн биет тооллого хийхэд 45,000 (Дөчинн таван мянган) төгрөгийн бал, 5,000 (Таван мянган) төгрөгийн дэвтэр дутагдсан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэснийг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8 дахь “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 2.1.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Тооллогоор дутагдсан бараа материалын үнийн 50,000 (Тавин мянган) төгрөгийг байгууллагын дарга, нягтлан бодогч нараар төлүүлэн, Төрийн сан дахь 100030000947 тоот төгрөгийн дансанд төлбөрийг төвлөрүүлэх.

5050350

D/2024-Akt

2. Аудитаар тогтоосон 50,000 (Тавин мянган) төгрөгийн төлбөрийн актыг бүрэн барагдуулж, нотлох баримтыг 2024 оны 05 дугаар сарын 10-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт<sup>1</sup> ирүүлэхийг Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын дарга Э.Амгаланбаяр, нягтлан бодогч Б.Уранчимэг нарт даалгав<sup>2,3</sup>.

#### ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН<sup>4</sup>:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

Б.МӨНХБАТ

Б.ДОЛЖМАА

<sup>1</sup> Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

<sup>2</sup> Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана"

<sup>3</sup> Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

<sup>4</sup> Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно